



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 09 -ны өдөр

Дугаар А/110

Эрдэнэт

Үзлэг зохион байгуулахад шаардагдах
эмнэлгийн хэрэгсэл, оношлуур
гаргах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16.5.1 Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хамтарсан “Өсвөр үеийн охид хөвгүүдийн эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах тухай” удирдамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Өсвөр үеийн охид хөвгүүдийн эрүүл мэндийн үзлэг зохион байгуулахад шаардагдах нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Үзлэгт шаардагдах эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын чанар, бүрэн бүтэн байдалд хяналт тавихыг Эмийн бодлогын хэрэгжилт, чанар, аюулгүй байдал, зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн /О.Анхбаяр/-т, Эрүүл мэндийн нөөцөөс гаргах эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын олголт, баримтжуулахыг нярав /Л.Даваажав/-д үүрэг болгосугай.

3. Эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын зарцуулалтад хяналт тавихыг Эх, хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /П.Хишгээ/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ХШҮДАХ мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д даалгасугай.

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 10. –р сарын
09. –ны өдрийн 4/110. –р тоот тушаалын хавсралт

Үзлэгт шаардагдах эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын жагсаалт

№	Эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын нэрс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Тэмбүү, ХДХВ-ын хурдавчилсан оношлуур	ширхэг	90	2,500	225,000
2	Нэг удаагийн амны хаалт	ширхэг	100	300	30,000
3	Нэг удаагийн үзлэгийн бээлий	хос	400	160	64,000
4	Гар ариутгагч	литр	3	13,000	39,000
Нийт					358,000

Жагсаалт гаргасан: ЭБХЧАБЗХХМэргэжилтэн *О.Анхбаяр* О.Анхбаяр

Хянасан: ССБМНБАжилтан *Н.Чулуун-Эрдэнэ* Н.Чулуун-Эрдэнэ